

---

**“ТӨРИЙН БАНК” ХУВЬЦААТ КОМПАНИ  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН  
ЭЧНЭЭ САНАЛ ХУРААЛТААР  
ШИЙДВЭРЛЭХ АСУУДЛЫН МАТЕРИАЛ**

---

**УЛААНБААТАР ХОТ**  
**2024 он**

## □ АГУУЛГА

1. Эчнээ санал хураах тухай зар
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг эчнээ санал хураалтаар явуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол
3. Эчнээ санал хураалтын тооллогын комиссын бүрэлдэхүүн
4. Эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудал:
  - “Төрийн банк” ХК-ийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
5. Эчнээ санал хураалтын шийдвэрийн төсөл
6. Эчнээ санал хураалтын саналын хуудасны загвар

## □ ЭЧНЭЭ САНАЛ ХУРААХ ТУХАЙ ЗАР

“Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 46 дугаар тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг эчнээ санал хураалтаар явуулахаар зарлаж байна.

- **Хувьцаа эзэмшигчдэд саналын хуудас хүргүүлэх хугацаа:** 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр
- **Саналын хуудсыг хүлээж авах эцсийн өдөр:** 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 18:00 цаг
- **Компанийн оноосон нэр:** “ТӨРИЙН БАНК” ХК
- **Хаяг:** Монгол улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу 7/1
- **Саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр:** 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдөр
- **Эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудал:**
  1. “Төрийн банк” ХК-ийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
- **Хувьцаа эзэмшигчдийн танилцах баримт бичгийн жагсаалт:**
  1. Эчнээ санал хураалтын шийдвэрийн төсөл;
  2. Эчнээ санал хураалтын саналын хуудас.

Хувьцаа эзэмшигч Та 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 18:00 цаг хүртэлх хугацаанд “Төрийн банк” ХК-ийн цахим хуудас [www.statebank.mn/](http://www.statebank.mn/), өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанид хандах, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу 7/1 хаягт байрлах “Төрийн банк” ХК-ийн Төв байрны 1-р давхар, эсхүл өөрт ойрхон байрлах “Төрийн банк” ХК-ийн салбар, нэгжид хандан хурлын материалтай танилцан, 2024 оны 10 дугаар сарын 02-ны бүртгэлийн өдрөөр эзэмшиж буй хувьцааны тоогоор санал өгөх боломжтой.

“Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу 7/1 хаягт байрлах “Төрийн банк” ХК-ийн Төв байранд болон хурал зохион байгуулах комиссын утсаар холбогдон авна уу.

Хурал зохион байгуулах комиссын **утас:** 75071881,  
**цахим шуудан:** [SBM\\_Shareholder@statebank.mn](mailto:SBM_Shareholder@statebank.mn)



ЭРСДЭЛГҮЙ ИРЭЭДҮЙН БАТАЛГАА

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Огноо: 2024.09.10

№ 46

Улаанбаатар хот

### “Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг эчнээ санал хураалтаар явуулах тухай

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4 дэх хэсэг, 61 дүгээр зүйлийн 61.1.5 дахь заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 65 дугаар зүйлийн 65.1, 65.4 дэх хэсэг, 67 дугаар зүйлийн 67.1, 67.5 дахь хэсэг, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3 дахь хэсэг, 73 дугаар зүйлийн 73.1, 73.3 дахь хэсэг, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан Хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (цаашид “Хурал гэх”)-ыг эчнээ санал хураалтаар явуулсугай.

2. Эчнээ санал хураалтын саналын хуудсыг хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэх өдрийг 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрөөр, хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсыг хүлээж авах сүүлийн өдрийг 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөр тус тус тогтоосугай.

3. Эчнээ санал хураах тухай мэдэгдлийг 2024 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, Монголын Хөрөнгийн Биржид тус тус хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Э.Уянга)-д даалгасугай.

4. Эчнээ санал хураах тухай зарыг “Төрийн банк” ХК, Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудас, өдөр тутмын хоёроос доошгүй сонин, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн дотор нийтэд мэдээлж, зарын давталтыг 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдөр анх зарласан хэлбэрээр дахин нийтэд мэдээлэхийг Гүйцэтгэх захирал (Ө.Гантөр)-д даалгасугай.

5. Эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудалд санал өгөх саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрөөр тогтоосугай.

6. Эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудлын жагсаалт, шийдвэрийн төсөл, саналын хуудас зэрэг хуралтай холбоотой бусад баримт бичгийг 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр үнэт цаасны брокер дилерийн компаниудад хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал (Ө.Гантөр)-д даалгасугай.



7. Эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудлын жагсаалтыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.
8. Эчнээ санал хураах тухай зарын загварыг 2 дугаар хавсралтаар баталсугай.
9. Эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг 3 дугаар хавсралтаар баталсугай.
10. Эчнээ санал хураалтын саналын хуудасны загварыг 4 дүгээр хавсралтаар баталсугай.
11. Эчнээ санал хураалтыг зохион байгуулах комиссыг 5 дугаар хавсралтад заасан бүрэлдэхүүнтэй байгуулсугай.
12. Эчнээ санал хураалтын тооллогын комиссыг 6 дугаар хавсралтад заасан бүрэлдэхүүнтэй байгуулсугай.
13. Эчнээ санал хураалтыг зохион байгуулахад шаардлагатай технологийн орчныг бүрдүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Ө.Гантөр)-д даалгасугай.
14. Хувьцаа эзэмшигчдийг холбогдох материалтай танилцах нөхцөл, боломжийг бүрдүүлэх, шаардлагатай мэдээллээр хангаж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг зохион байгуулах комисс (Д.Сугар)-т даалгасугай.
15. “Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Б.Тэлмүүн)-ыг томилсугай.
16. Эчнээ санал хураалтаар шийдвэрлэсэн асуудал, шаардлагатай бусад материалыг Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох бусад журамд заасан хугацаанд Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Э.Уянга)-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.ТЭЛМҮҮН


“Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 46 дугаар  
тогтоолын 6 дугаар хавсралт



### ЭЧНЭЭ САНАЛ ХУРААЛТЫН ТООЛЛОГЫН КОМИСС

- Комиссын дарга:** Дотоод хяналт шалгалтын газрын захирал А.Батмөнх
- Комиссын гишүүд:** Аж ахуй, аюулгүй байдлын газрын захирал О.Баасансүрэн  
Хөрөнгө зохицуулалтын газрын захирал Д.Жадамбаа  
Мэдээллийн технологийн газрын Хөгжүүлэлтийн хэлтсийн  
захирал Б.Цэндсүрэн
- Комиссын нарийн  
бичгийн дарга:** Харилцагчийн үйлчилгээний албаны менежер Л.Булгаа

“Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 46 дугаар  
тогтоолын 1 дүгээр хавсралт



**ЭЧНЭЭ САНАЛ ХУРААЛТААР  
ШИЙДВЭРЛЭХ АСУУДЛЫН ЖАГСААЛТ**

1. “Төрийн банк” ХК-ийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

~oOo~

## “ТӨРИЙН БАНК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ

### “Төрийн банк” ХК-ийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 73 дугаар зүйлийн 73.11 дэх хэсэг, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.1 дахь заалт, “Төрийн банк” ХК-ийн 2024 оны ... дугаар сарын ...-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Төрийн банк” ХК-ийн дүрэмд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/4 дүгээр зүйлийн 4.12 дахь хэсэг:

“4.12. Банк нь Шилэн дансны тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан мэдээллийг хуульд заасны дагуу хүртээмжтэй хэлбэрээр нийтэд мэдээлнэ.”

2/4 дүгээр зүйлийн 4.13 дахь хэсэг:

“4.13. Банк нь байгаль орчин, нийгэм, засаглалын бодлого, хүний эрхийн хэрэгжилтийн талаарх тайлан, мэдээллийг жил бүр нийтэд мэдээлнэ.”

3/11 дүгээр зүйлийн 11.13 дахь хэсэг:

“11.13. Энэ дүрмийн 10.11 дэх хэсэгт заасны дагуу түр томилогдсон ТУЗ-ийн гишүүн нь ТУЗ-ийн гишүүний эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.”

4/15 дугаар зүйлийн 15.15 дахь хэсэг:

“15.15. Энэ дүрмийн 4.12-т заасан мэдээллийг нийтэд мэдээлэх, эрх бүхий байгууллагад тайлагнах үүргийг Гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээнд тусгана.”

2. “Төрийн банк” ХК-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.13 дахь хэсгийн 10.13.9 дэх заалтын “тодорхойлох” гэсний дараа “эд хөрөнгийг акталж, данснаас хасах эсэх асуудлыг эрх бүхий байгууллагаас санал авсны үндсэн дээр шийдвэрлэх;” гэж нэмсүгэй.

3. “Төрийн банк” ХК-ийн дүрмийн дараах зүйлийн хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэг:

“3.2. Банкны эрхэм зорилго нь харилцагчийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн байгаль орчинд ээлтэй, хүний эрхийг дээдэлсэн, нийгмийн хариуцлагатай, ил тод, сайн засаглалтай, ногоон хөгжил, дундаж давхаргыг бойжуулах, дэмжихэд чиглэсэн санхүүгийн цогц үйлчилгээг дэвшилтэт цахим технологи ашиглан тогтвортой, хүртээмжтэй хүргэх тогтолцоог бүрдүүлэхэд оршино.”

2/10 дугаар зүйлийн 10.10 дахь хэсэг:

“10.10. ТУЗ-ийн гишүүнд Засгийн газар, эрх бүхий байгууллагаас тогтоосон жишгийн хүрээнд ТУЗ-ийн дэргэдэх хороонд ажилласан байдлыг харгалзан нэмэгдэл цалин олгоно.”



3/10 дугаар зүйлийн 10.13 дахь хэсгийн 10.13.26 дахь заалт:

“10.13.26. Банкны байгаль орчин, нийгэм, засаглалын бодлого болон үйл ажиллагааны талаарх бодлого, журмыг батлах;”

4/11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг:

“11.1. Төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь төрийг төлөөлөх ТУЗ-ийн ердийн гишүүнд шаардлага хангасан нэр дэвшигчийг ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороонд санал болгох бөгөөд Нэр дэвшүүлэх хороо тухайн нэр дэвшиж байгаа этгээд нь холбогдох хууль тогтоомжид заасан шалгуурыг хангасан эсэх талаар эрх бүхий байгууллагаас мэдэгдэл, зөвшөөрлийг авсны үндсэн дээр ТУЗ-ийн ердийн гишүүнээр томилуулах саналаа ХЭХ-д танилцуулан шийдвэрлүүлнэ.”

5/11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг:

“11.2 Төрийг төлөөлөх ТУЗ-ийн ердийн гишүүд нь Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөллөөс бүрдэж болно. Тухайн байгууллагаас хууль тогтоомжид заасан шалгуур хангасан албан хаагч томилох боломжгүй тохиолдолд Төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч шаардлага хангасан албан хаагчийг нэр дэвшүүлнэ.”

4. “Төрийн банк” ХК-ийн дүрмийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн “захирлуудын зөвлөлийн гишүүн” гэснийг “тэргүүн дэд захирал, дэд захирал, банкны төвийн газрын захирал, салбарын захирал” гэж тус тус өөрчилсүгэй.

5. “Төрийн банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас гарсан шийдвэрийг холбогдох эрх бүхий байгууллагад, нээлттэй мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд тус тус хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Э.Уянга)-д үүрэг болгосугай.

6. “Төрийн банк” ХК-ийн дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хууль тогтоомжид заасны дагуу Улсын бүртгэлд бүртгүүлэх, холбогдох эрх бүхий байгууллагуудад хүргүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал (Ө.Гантөр)-д үүрэг болгосугай.

## **ХУРЛЫН ДАРГА**

## □ САНАЛЫН ХУУДАСНЫ ЗАГВАР

“Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 46 дугаар  
тогтоолын 4 дүгээр хавсралт



### ЭЧНЭЭ САНАЛ ХУРААЛТЫН САНАЛЫН ХУУДАС

Компанийн оноосон нэр: “ТӨРИЙН БАНК” ХК

Хувьцаа эзэмшигчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр:

\_\_\_\_\_

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар:

--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар:

--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

Эзэмшиж буй хувьцааны төрөл: энгийн

Эзэмшиж буй хувьцааны тоо: \_\_\_\_\_

Энэхүү саналын хуудсаар 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 18:00 цаг хүртэлх хугацаанд “Төрийн банк” ХК-ийн цахим хуудас [www.statebank.mn/](http://www.statebank.mn/), өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанид хандах, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу 7/1 хаягт байрлах “Төрийн банк” ХК-ийн Төв байрны 1-р давхар, эсхүл өөрт ойрхон байрлах “Төрийн банк” ХК-ийн салбар, нэгжид хандан санал өгнө.

Саналын хуудсыг хүлээж авах эцсийн өдөр: 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр

№	Хэлэлцэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	“Төрийн банк” ХК-ийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай			

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг, гарын үсгийн тайлал: \_\_\_\_\_  
/ \_\_\_\_\_ /

Огноо: \_\_\_\_\_

Саналын хуудсыг бүртгэж, хүлээж авсан ажилтны гарын үсэг, гарын үсгийн тайлал:

/ \_\_\_\_\_ /

### **САНАМЖ**

1. Хувьцаа эзэмшигч Та 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн 2024 оны 11 дүгээр сарын 01-ны өдрийн 18:00 цаг хүртэлх хугацаанд 2024 оны 10 дугаар сарын 02-ны бүртгэлийн өдрөөр эзэмшиж буй хувьцааны тоогоор санал өгөх боломжтой.
2. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт (✓) тэмдэглэгээг хийнэ үү.
3. Та саналаа өгөхдөө дараах хэлбэрээр өгөх боломжтой. Үүнд:
  - “Төрийн банк” ХК-ийн цахим хуудас /[www.statebank.mn](http://www.statebank.mn)/-аар дамжуулан саналаа цахимаар өгөх;
  - Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу 7/1 хаягт байрлах “Төрийн банк” ХК-ийн Төв байрны 1-р давхар, эсхүл өөрт ойрхон байрлах “Төрийн банк” ХК-ийн салбар, нэгжид биеэр ирж саналаа өгөх;
  - Өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компаниар дамжуулан саналаа өгөх;
  - [SBM\\_Shareholder@statebank.mn](mailto:SBM_Shareholder@statebank.mn) хаягаар саналын хуудсыг илгээх.
4. Та “Төрийн банк” ХК-ийн төв байранд биеэр ирж санал өгөх, өөрийн үнэт цаасны компаниар дамжуулан санал өгөх, саналын хуудсаа [SBM\\_Shareholder@statebank.mn](mailto:SBM_Shareholder@statebank.mn) хаягаар илгээн санал өгөх тохиолдолд дараах зүйлийг анхаарна уу. Үүнд:
  - Хувьцаа эзэмшигч хувь хүн бол саналын хуудас дээр гарын үсэг зурж баталгаажуулан, иргэний үнэмлэхний хуулбарыг хавсаргах бөгөөд хэрэв хуулийн этгээд бол эрх бүхий этгээд гарын үсэг зурж хуулийн этгээдийн тэмдгийг дарж баталгаажуулан, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг хавсаргана.
  - Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэн санал өгч байгаа бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч нотариатаар баталгаажуулж, итгэмжлэлийн хамт хүчинтэйд тооцно.
  - Засварласан, балласан, залруулгатай саналын хуудас нь хүчингүйд тооцогдоно.
5. Хэлэлцэх асуудалтай холбогдох асуулт, санал байгаа тохиолдолд дор бичиж өгнө үү.

**Энэ хэсгийг хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комисс бөглөнө.**


Саналын хуудсыг хүчинтэйд тооцох эсэх: Тийм/Үгүй  
Тооллогын комиссын даргын гарын үсэг, гарын үсгийн тайлал:  
\_\_\_\_\_/\_\_\_\_\_/

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон бол түүний шалтгаан:

\_\_\_\_\_

Хувьцаа эзэмшигчийн асуулт, санал:

\_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_



📞 1800-1881

🌐 [www.statebank.mn](http://www.statebank.mn)

📘 /StatebankMN

📺 /StatebankMN